ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код:** ДГА-2026/66/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Нарангарав
Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn
Аудитор: Н.Түвшинбаатар
Цахим хаяг: tuvshinbaatar.n@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/271

танай__________-ны №__________-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

### Аудитын гол асуудал

Ээлжийн амралттай дөрвөн албан хаагчид тус тус 1 хоногийн цалин нийт 0.5 сая төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна"*, *Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтэй тохирсон цалин хөлс авах"*, *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант онд халаалтын зардлыг 11.2 сая төгрөгөөр илүү шилжүүлж, авлага үүсгэн зардлын хэмнэлтийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15

442505099

дугаар зүйлийн 15.2.1 "*байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Цалингийн зардлыг нийгмийн даатгалын 1-р сарын тайланд 1.2 сая төгрөгөөр, 7-р сарын тайланд 0.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.Нийт НДШ-ийн дүнг 1.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хууль 32.2.2-т "*орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 15,484,750.00 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 15,484,750.00 | - |
| 3121 | Төгрөг | 15,484,750.00 | - |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 15,484,750.00 | - |
| 33 | АВЛАГА | - | 27,390,638.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 6,161,488.00 |
| 335 | Бусад авлага | - | 21,229,150.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 21,229,150.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 85,382,227.03 | 70,463,536.00 |
| 351 | Түүхий эд материал | 1,048,300.00 | 530,250.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 186,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 862,300.00 | 530,250.00 |
| 354 | Хангамжийн материал | 84,333,927.03 | 69,933,286.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,019,300.00 | 4,144,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 66,794,495.02 | 61,979,874.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 570,000.00 | 570,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 442,760.01 | 1,960,560.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,507,372.00 | 1,278,452.00 |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 100,866,977.03 | 97,854,174.00 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,172,091,479.70 | 5,773,548,757.24 |
| 392 | Биет хөрөнгө | 2,598,634,080.34 | 5,229,838,258.08 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,920,639,756.75 | 5,168,676,118.75 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - 561,973,090.27 | - 662,079,860.19 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,150,000.00 | 19,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 18,210,000.16 | - 19,700,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 481,463,260.00 | 724,647,850.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 271,063,560.76 | - 246,987,976.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 202,437,903.70 | 195,823,964.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 175,973,144.78 | - 144,652,983.16 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,925,850.00 | 201,796,716.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - 2,762,894.14 | - 7,385,571.05 |
| 393 | Биет бус хөрөнгө | 573,457,399.36 | 543,710,499.16 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 576,493,000.00 | 547,693,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - 3,035,600.64 | - 3,982,500.84 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,172,091,479.70 | 5,773,548,757.24 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,272,958,456.73** | **5,871,402,931.24** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 11,303,795.48 |
| 413 | Өглөг | - | 11,303,795.48 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 240,043.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 11,063,752.48 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 11,063,752.48 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 11,303,795.48 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,272,958,456.73 | 5,860,099,135.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 756,435,814.51 | 756,435,814.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 756,435,814.51 | 756,435,814.51 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,516,522,642.22 | 5,103,663,321.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,536,818,935.33 | 2,516,522,642.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - 20,296,293.11 | 2,587,140,679.03 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,272,958,456.73 | 5,860,099,135.76 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,272,958,456.73** | **5,871,402,931.24** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,528,189,761.01 | 2,364,734,651.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,045,369,100.00 | 2,122,367,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,045,369,100.00 | 2,122,367,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 482,820,661.01 | 242,367,651.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 285,411,161.01 | 237,087,651.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,440,300.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 164,969,200.00 | 280,000.00 |
| 12 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 230,065,844.00 | 2,844,291,860.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 230,065,844.00 | 2,844,291,860.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 230,065,844.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 141,392,800.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 88,673,044.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 2,807,878,660.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 36,413,200.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,758,255,605.01 | 5,209,026,511.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,778,551,898.12 | 2,588,185,347.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,403,180,917.22 | 2,501,503,958.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,535,343,851.15 | 1,808,563,378.00 |
| 210101 | Үндсэн цалин | 849,468,978.15 | 892,594,475.00 |
| 210102 | Нэмэгдэл | 444,308,853.00 | 519,321,503.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 156,301,026.00 | 380,231,200.00 |
| 210104 | Урамшуулал | 85,264,994.00 | 16,416,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 192,201,753.00 | 211,173,341.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,295,342.00 | 135,475,306.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,452,452.00 | 18,522,830.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,758,040.00 | 10,034,648.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,703,093.00 | 9,594,826.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,992,826.00 | 37,545,731.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 195,994,107.51 | 152,056,426.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 68,842,962.66 | 15,808,130.46 |
| 210302 | Түлш, халаалт | 119,169,252.85 | 122,783,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,981,892.00 | 13,464,396.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 59,993,800.98 | 73,518,678.51 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,919,400.00 | 9,619,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 340,000.00 | 4,609,700.01 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,271,653.10 | 2,787,734.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 480,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 49,462,747.88 | 56,022,144.02 |
| 2105 | Нормативт зардал | 125,510,111.40 | 55,145,930.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 282,910.00 | 332,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 120,205,601.40 | 54,813,880.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,021,600.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,082,700.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,705,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 377,700.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,632,000.00 | 7,850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,632,000.00 | 7,850,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 100,305,537.00 | 1,829,506.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 92,793,805.00 | 454,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,894,400.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 166,578.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,736.00 | 89,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,812,800.00 | 593,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,754,796.00 | 503,828.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 184,117,056.18 | 191,366,698.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,330,000.00 | 186,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 750,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 176,037,056.18 | 191,180,698.03 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 375,370,980.90 | 86,681,388.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 152,919,850.00 | 28,305,376.72 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 22,599,776.72 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 94,024,600.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 58,895,250.00 | 5,705,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 222,451,130.90 | 58,376,011.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 222,451,130.90 | 57,874,511.86 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 501,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,778,551,898.12 | 2,588,185,347.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | - 20,296,293.11 | 2,620,841,163.46 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 33,700,484.43 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 33,700,484.43 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - 33,700,484.43 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | - 20,296,293.11 | 2,587,140,679.03 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,528,189,761.01** | **2,366,104,798.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,045,369,100.00 | 2,122,367,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,045,369,100.00 | 2,122,367,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 482,820,661.01 | 243,737,798.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 285,411,161.01 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 238,457,798.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,440,300.00 | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 164,969,200.00 | 280,000.00 |
| 12 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 141,392,800.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 141,392,800.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 141,392,800.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 141,392,800.00 | - |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,669,582,561.01** | **2,366,104,798.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,585,880,891.01 | 2,363,129,748.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,210,509,910.11 | 2,266,419,209.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,535,343,851.15 | 1,790,433,208.96 |
| 210101 | Үндсэн цалин | 849,468,978.15 | 879,550,155.00 |
| 210102 | Нэмэгдэл | 444,308,853.00 | 515,093,932.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 156,301,026.00 | 367,691,326.00 |
| 210104 | Урамшуулал | 85,264,994.00 | 28,097,795.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 192,201,753.00 | 236,222,888.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,295,342.00 | 160,524,853.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,452,452.00 | 18,522,830.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,758,040.00 | 10,034,648.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,703,093.00 | 9,594,826.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,992,826.00 | 37,545,731.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 183,870,278.86 | 163,256,426.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 69,495,042.66 | 15,808,130.46 |
| 210302 | Түлш, халаалт | 105,130,036.20 | 132,757,396.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,245,200.00 | 14,690,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,381,189.10 | 15,190,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,462,100.00 | 2,194,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,368,444.00 | 4,167,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,271,653.10 | 2,518,193.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 298,900.00 | 198,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,980,092.00 | 6,112,157.00 |
| 2105 | Нормативт зардал | 129,215,045.00 | 43,556,310.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 606,600.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 123,586,845.00 | 40,894,010.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,021,600.00 | 2,662,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,728,000.00 | 4,891,380.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,135,000.00 | 1,374,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,400,000.00 | 1,920,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,193,000.00 | 1,597,280.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,632,000.00 | 7,850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,632,000.00 | 7,850,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 104,387,793.00 | 5,018,896.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 95,026,061.00 | 3,643,890.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,654,400.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 166,578.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,736.00 | 89,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,902,800.00 | 593,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,754,796.00 | 503,828.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 750,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 750,000.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 375,370,980.90 | 96,710,538.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 152,919,850.00 | 28,305,376.72 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 22,599,776.72 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 94,024,600.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 58,895,250.00 | 5,705,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 222,451,130.90 | 68,405,161.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 222,451,130.90 | 57,874,511.86 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,530,650.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2) | 2,585,880,891.01 | 2,363,129,748.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 83,701,670.00 | 2,975,050.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 81,016,920.00 | 18,459,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 81,016,920.00 | 18,459,800.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 81,016,920.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 18,459,800.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 81,016,920.00 | 18,459,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - 81,016,920.00 | - 18,459,800.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 2,684,750.00 | - 15,484,750.00 |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 15,484,750.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | - | 2,536,818,935.33 | 3,293,254,749.84 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 756,435,814.51 | - | 2,536,818,935.33 | 3,293,254,749.84 |
| C09 | Тайлант үеийн үр дүн | - | - | - 20,296,293.11 | - 20,296,293.11 |
| C10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | - | 2,516,522,642.22 | 3,272,958,456.73 |
| C11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | - | 2,516,522,642.22 | 3,272,958,456.73 |
| C12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 756,435,814.51 | - | 2,516,522,642.22 | 3,272,958,456.73 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,587,140,679.03 | 2,587,140,679.03 |
| C20 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | - | 5,103,663,321.25 | 5,860,099,135.76 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Биелэлт, хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **12200** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,344,551,000.00** | **2,064,492,488.14** | **280,058,511.86** | **88.1%** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,344,551,000.00 | 2,064,492,488.14 | 280,058,511.86 | 88.1% |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,344,551,000.00 | 2,064,492,488.14 | 280,058,511.86 | 88.1% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,344,551,000.00 | 2,064,492,488.14 | 280,058,511.86 | 88.1% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,299,329,500.00 | 2,041,642,711.42 | 257,686,788.58 | 88.8% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,671,022,100.00 | 1,588,849,218.96 | 82,172,881.04 | 95.1% |
| 210101 | Үндсэн цалин | 858,485,700.00 | 805,018,806.00 | 53,466,894.00 | 93.8% |
| 210102 | Нэмэгдэл | 430,254,500.00 | 398,958,911.96 | 31,295,588.04 | 92.7% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 260,127,100.00 | 356,773,706.00 | - 96,646,606.00 | 137.2% |
| 210104 | Урамшуулал | 122,154,800.00 | 28,097,795.00 | 94,057,005.00 | 23.0% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 216,362,700.00 | 209,503,100.00 | 6,859,600.00 | 96.8% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 149,359,400.00 | 142,499,800.00 | 6,859,600.00 | 95.4% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,802,300.00 | 16,802,300.00 | - | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,386,800.00 | 8,386,800.00 | - | 100.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,368,800.00 | 8,368,800.00 | - | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,445,400.00 | 33,445,400.00 | - | 100.0% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 181,826,800.00 | 163,256,426.46 | 18,570,373.54 | 89.8% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,509,100.00 | 15,808,130.46 | 10,700,969.54 | 59.6% |
| 210302 | Түлш, халаалт | 140,626,800.00 | 132,757,396.00 | 7,869,404.00 | 94.4% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,690,900.00 | 14,690,900.00 | - | 100.0% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,073,100.00 | 9,161,900.00 | 5,911,200.00 | 60.8% |
| 210401 | Бичиг хэрэг | 2,029,700.00 | 2,194,000.00 | - 164,300.00 | 108.1% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,023,400.00 | 389,000.00 | 634,400.00 | 38.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,228,500.00 | 1,798,193.00 | 430,307.00 | 80.7% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,396,900.00 | 198,250.00 | 2,198,650.00 | 8.3% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,394,600.00 | 4,582,457.00 | 2,812,143.00 | 62.0% |
| 2105 | Нормативт зардал | 131,713,300.00 | 34,651,990.00 | 97,061,310.00 | 26.3% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 899,800.00 | - | 899,800.00 | 0.0% |
| 210502 | Хоол, хүнс | 121,817,400.00 | 31,989,690.00 | 89,827,710.00 | 26.3% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,996,100.00 | 2,662,300.00 | 6,333,800.00 | 29.6% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,718,900.00 | 6,351,180.00 | 3,367,720.00 | 65.3% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,833,800.00 | 2,833,800.00 | - | 100.0% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,287,800.00 | 1,920,100.00 | 3,367,700.00 | 36.3% |
| 210604 | Урсгал засвар | 1,597,300.00 | 1,597,280.00 | 20.00 | 100.0% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,996,900.00 | 7,850,000.00 | 18,146,900.00 | 30.2% |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,996,900.00 | 7,850,000.00 | 18,146,900.00 | 30.2% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,615,700.00 | 22,018,896.00 | 25,596,804.00 | 46.2% |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 33,394,600.00 | 20,643,890.00 | 12,750,710.00 | 61.8% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,814,000.00 | - | 3,814,000.00 | 0.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,079,900.00 | 166,578.00 | 913,322.00 | 15.4% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо | 89,600.00 | 89,600.00 | - | 100.0% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,700.00 | 22,000.00 | 55,700.00 | 28.3% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,347,200.00 | 593,000.00 | 2,754,200.00 | 17.7% |
| 210807 | Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж | 5,812,700.00 | 503,828.00 | 5,308,872.00 | 8.7% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,221,500.00 | 22,849,776.72 | 22,371,723.28 | 50.5% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 45,221,500.00 | 22,849,776.72 | 22,371,723.28 | 50.5% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,599,900.00 | 22,599,776.72 | 123.28 | 100.0% |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 22,371,600.00 | - | 22,371,600.00 | 0.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 250,000.00 | - | 100.0% |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **2,344,551,000.00** | **2,064,492,488.14** | **280,058,511.86** | **88.1%** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **243,236,298.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 243,236,298.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 243,236,298.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 201,583,990.00 |
| 210101 | Үндсэн цалин | 74,531,349.00 |
| 210102 | Нэмэгдэл | 116,135,021.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,917,620.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,719,788.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,025,053.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,720,530.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,647,848.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,226,026.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,100,331.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,028,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,778,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 720,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,529,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 8,904,320.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,904,320.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 243,236,298.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **243,236,298.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 238,457,798.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,498,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 280,000.00 |

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 15,484,750.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 15,484,750.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 5,455,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,455,600.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,029,150.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,029,150.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | - | 15,484,750.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 15,484,750.00 |

# 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 107.6 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 68.6 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд: мөнгөн хөрөнгийн дүнг 0.2 сая төгрөгөөр илүү, Санхүүгийн үр дүнгийн тайланд: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 17.3 сая төгрөгөөр дутуу, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 15.9 сая төгрөгөөр илүү, Мөнгөн гүйлгээний тайланд: ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2.5 сая төгрөгөөр илүү тусгаж зөрүүтэй тайлагнасанг залруулав. (Завсар)

2. Санхүүгийн байдлын тайланд: Бараа материалын дүнг 5.3 сая төгрөгөөр дутуу, байгууллагаас авах авлагыг 10.0 сая төгрөгөөр дутуу, Санхүүгийн үр дүнгийн тайланд: Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа, материалын дүнг 5.3 сая төгрөгөөр дутуу, түлш, халаалтын зардлыг 10.4 сая төгрөгөөр илүү, цэвэр, бохир усны зардлыг 1.2 сая төгрөгөөр илүү, Төсвийн гүйцэтгэлийн тайланд: үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.3 сая төгрөгөөр дутуу тусгаж зөрүүтэй тайлагнасанг залруулав.

Аудитаар залруулагдаагүй 33.4 сая төгрөгийн 6 зөрчилд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 41.7 сая төгрөгөөс хэтрээгүй тул *Өөрчлөлтгүй дүгнэлт* өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Ээлжийн амралттай дөрвөн албан хаагчид тус тус 1 хоногийн цалин нийт 487,849 (дөрвөн зуун наян долоон мянга найман зуун дөчин ес) төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2 Албан шаардлага

1. Тус байгууллага нь 2025 оны 9 сарын 16-ны өдөр “паар худалдан авч, завсарлуулах” 440,000 төгрөгийг түлш халаалтын зардлаас гарган зарцуулсан нь Төсвийн тухай

хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 -т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” журмын хоёр дугаар хавсралтын заалттай нийцэхгүй байна. (Завсар)

2. Мөнгөн гүйлгээний журналаас шүүж үзэхэд Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 0.2 сая төгрөгөөр цавуу, шрүп, Багаж, техник, хэрэгслийн зардлаас 1.9 сая төгрөгөөр хаалга, цоож, сандал, Урсгал засвар зардлаас 0.6 сая төгрөгөөр шал угаагч, алчуур, хогийн шүүр, хогийн сав, сагс, температур хэмжигч, Түлш, халаалтын зардлаас 0.3 сая төгрөгөөр ахуйн хэрэглээний хийн газ худалдан авч тус тус  эдийн засгийн ангилал зөрүүтэй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 -т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” журмын хоёр дугаар хавсралтын заалттай нийцэхгүй байна.

3. Даатгуулагчаас төлөх 18.5 сая төгрөгийн НДШ-ын зардлыг ажил олгогчоос төлөх зардлаас зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 -т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” журмын хоёр дугаар хавсралтын заалттай нийцэхгүй байна.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1 Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 <u>Илрүүлэлт:</u>

Цалингийн зардлыг нийгмийн даатгалын 1-р сарын тайланд 1.2 сая төгрөгөөр, 7-р сарын тайланд 0.3 сая төгрөгөөр, НДШ-ийн дүнг  1.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хууль 32.2.2.орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u>

Нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тусгасан цалингийн зардал, НДШ-ийн дүнг засварлан тайлагнах

## 2 Нийцсэн ба зохистой байх асуудал

1.2 <u>Илрүүлэлт:</u>

Шилэн дансны цахим системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 3,104.9 сая төгрөгийн 19 тушаал, шийдвэрээс 349.6 сая төгрөгийн 10 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u>

Шилэн дансанд мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган,төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн. | 1 | 35,991.1 | - | - | 1 | 35,991.1 | 1 | 35,991.1 | - | - |
| Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн | 1 | 32,589.2 | | | 1 | 32,589.2 | 1 | 32,589.2 | | |
| **Дүн** | **2** | **68,580.3** | | | **2** | **68,580.3** | **2** | **68,580.3** | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган,төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалин илүү тооцож олгосон. | 1 | 487.8 | 1 | 487.8 | - | - | - | - | - | - |
| Зардлыг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 440.0 | - | - | 1 | 440.0 | - | - | - | - |
| Эдийн засгийн ангилал зөрүүтэй зарцуулсан | 1 | 18,479.9 | - | - | 1 | 18,479.9 | - | - | - | - |
| Зардлын хэмнэлтийг зарцуулсан | 1 | 11,200.0 | - | - | 1 | 11,200.0 | - | - | - | - |
| Цалингийн зардал, НДШ-ийн дүнг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тусгасан. | 1 | 2,817.9 | - | - | - | - | 1 | 2,817.9 | - | - |
| **Дүн** | **5** | **33,425.6** | **1** | 487.8 | **3** | **30,119.9** | **1** | 2,817.9 | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй. | 1 | 0 | - | - | - | - | 1 | 0 |
| **Дүн** | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **0** |